



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 17/144

Мандалговь

“Тэлмэн нетворк” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймаг, сумдын ЗДТГ-ын тоног төхөөрөмж” /Дундговь/-ийн гүйцэтгэгчээр шалгарсан “Тэлмэн нетворк” ХХК-тай 98,530,861 (ерэн найман сая таван зуун гучин мянга найман зуун жаран нэг) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Тоног төхөөрөмжийг батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тэлмэн нетворк” ХХК-ний захирал (Э.Сүхбат)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Н.Түвшинжаргал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150165